



**МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН  
БАЙНГЫН ХОРООНЫ  
ТОГТООЛ**

2014 оны 04 сарын 17 өдөр

Дугаар 07

Улаанбаатар хот

**Ажлын хэсэг байгуулах тухай**

Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.5 дахь хэсгийг үндэслэн Хууль зүйн байнгын хорооноос ТОГТООХ нь:

1. Улсын Их Хурлын гишүүдээс гаргасан саналын дагуу Улсын дээд шүүхийн нийт шүүгчдийн хуралдаанаар зарим хэргийг гомдлын дагуу хянан хэлэлцэж байгаа нь Монгол Улсын Үндсэн хуулийн холбогдох заалттай нийцэж байгаа эсэхийг судлан үзэж шаардлагатай бол холбогдох хууль тогтоомжийн төсөлд нэмэлт, өөрчлөлт оруулах төслийг боловсруулах үүрэг бүхий ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэйгээр байгуулсугай:

**Ажлын хэсгийн ахлагч:**

О.Баасанхүү - Улсын Их Хурлын гишүүн

**Гишүүд:**

З.Баянсэлэнгэ - Улсын Их Хурлын гишүүн  
Д.Лүндээжанцан - Улсын Их Хурлын гишүүн  
Х.Тэмүүжин - Улсын Их Хурлын гишүүн  
Д.Оюунхорол - Улсын Их Хурлын гишүүн

2. Ажлын хэсэгт мэргэжил, арга зүйн туслалцаа үзүүлэх ажлын дэд хэсгийг дараах бүрэлдэхүүнтэйгээр байгуулсугай:

М.Батсуурь - Улсын дээд шүүхийн Захиргааны танхимын тэргүүн

С.Нямжав - Улсын дээд шүүхийн Эрүүгийн танхимын тэргүүн

Б.Ундрах - Улсын дээд шүүхийн Иргэний танхимын тэргүүн

Б.Баасандорж - Хууль зүйн яамны Хууль зүйн нэгдсэн бодлогын газрын дарга

Т.Бат-Өлзий - Хууль зүйн яамны Эрх зүйн шинэчлэлийн бодлогын газрын дарга

Л.Мөнхцэцэг

-Хууль зүйн яамны Эрх зүйн шинэчлэлийн бодлогын газрын ахлах мэргэжилтэн

Э.Сэлэнгэ

-Хууль зүйн яамны Эрх зүйн шинэчлэлийн бодлогын газрын мэргэжилтэн

Э.Түвшинжаргал

-Хууль зүйн байнгын хорооны ахлах зөвлөх

Ч.Ариунхур

-Хууль зүйн байнгын хорооны зөвлөх

Ч.Батбямба

-Хууль зүйн байнгын хорооны референт

ХУУЛЬ ЗҮЙН БАЙНГЫН  
ХОРООНЫ ДАРГА



Ш.ТҮВДЭНДОРЖ